



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Г “Малын индексжүүлсэн даатгалыг 7
санхүүгийн нэмэлт тайланд бүртгэх,
тайлагнах түр заавар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 4.3, 29.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Малын индексжүүлсэн даатгалыг санхүүгийн нэмэлт тайланд бүртгэх, тайлагнах түр заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү түр зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫГ
САНХҮҮГИЙН НЭМЭЛТ ТАЙЛАНД БҮРТГЭХ,
ТАЙЛАГНАХ ТҮР ЗААВАР**

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү түр зааврыг Малын индексжүүлсэн даатгал /цаашид “МИД” гэх/-ын хураамж, нөөц сан, давхар даатгал, нөхөн төлбөрийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын санхүүгийн нэмэлт тайлангуудад тусгахад баримтална.

1.2. Энэхүү түр зааврыг МИД-ын төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд мөрдөж ажиллана.

1.3. МИД-ыг Хорооны 2009 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийн 1.7-д “мал амьтдын даатгал”-ын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүн гэж үзнэ.

ХОЁР. Санхүүгийн нэмэлт тайланд бүртгэх

2.1. Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын 6 дугаар хавсралтын нийт хураамжийн орлого гэсэн /1.1/ мөрөнд МИД-ын нийт хураамжийг, давхар даатгал гэсэн /1.1.1/ мөрөнд МИД-аас давхар даатгагчид шилжүүлсэн мөнгөний тухайн даатгагчид ногдох хэсгийг тус тус бүртгэнэ.

2.2. Даатгалын гэрээ байгуулсан жилд даатгалын цэвэр хураамжийн орлогоос гуравны нэгтэй тэнцэх хэсгийг орлогод тооцсон хураамжийн нөөц, үлдэх гуравны хоёртой тэнцэх орлогоос давхар даатгалын хураамжийг хасч, орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг тус тус байгуулна.

2.3. Даатгалын гэрээ байгуулсны дараах буюу нөхөн төлбөр олгох жилд орлогод тооцоогүй нөөцийг тухайн дүнгээр нь орлогод тооцсон хураамжид шилжүүлж тооцно.

2.4. Даатгалын нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжаас олгоно.

2.5. Даатгалын нөхөн төлбөр нь даатгалын эрсдэл тооцсон хураамжийн тодорхой хувь хэмжээ буюу МИД-ын төсөл хэрэгжүүлэгч нэгж болон төсөлд оролцогч даатгалын компаниудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд заасан хувь хэмжээтэй тэнцүү, өөрөөр хэлбэл гэрээний заасан хувь хэмжээнээс хэтрэхгүй байна.

2.6. Энэ түр зааврын 1.1-д заасан журмын 8 дугаар хавсралтад дурьдсан нийт нөхөн төлбөрийг санхүүгийн нэмэлт тайланд тусгахдаа Засгийн газар болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оролцуулан нийлбэр дүнгээр тусгана.

ГУРАВ. Бусад

3.1. Төсөлд оролцогч компаниуд МИД-тай холбоотой энэхүү зааварт зааснаас бусад зохицуулалтыг Сангийн сайдын 2010 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 16 дугаар тушаалаар батлагдсан “МИД-ын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу хэрэгжүүлнэ.

--ooOoo--